

Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн бэлгийн замын үрэвсэлт өвчний байдал

Ө. Жүгдэр

*Улсын Эх Нялхсын Эрдэм
шинжилгээний төвийн эрдэмтэн
нарийн бичгийн дарга*

С. Дэмбэрэлсүрэн

*Улсын Эх Нялхсын Эрдэм
шинжилгээний төвийн эрдэм
шинжилгээний ажилтан*

Эмэгтэйчүүдийн дунд тохиолдох өвчлөлийн дотор бэлэг эрхтний үрэвсэлт өвчин 60–65% тохиолдож байна. Эмэгтэйчүүдийн үрэвсэлт өвчин ихэвчлэн өгсөх замаар халдварлаж архагших хандлагатай байдаг бөгөөд удаан хугацаагаар үргэлжилж үе үе сэдэрч дахина. Үрэвсэлт өвчний дараа ихэвчлэн наалдац үүсч дэргэдэх эрхтний үйл ажиллагаа алдагдаж, дааврын солилцооны болон биений юмны үйл ажиллагааны хямралд хүргэдэг. Ийнхүү эмэгтэйчүүдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж хөдөлмөрийн чадвар алдалтанд хүргэдэгээрээ нийгэмд ч тодорхой хэмжээгээр нөлөөлдөг юм.

Эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн замын үрэвсэлт өвчний талаар сүүлийн жилүүдэд хийсэн дорвитой судлагааны ажил үгүй байна. Эрүүл мэндийн яамны 1993 оны дүн бүртгэлийн мэдээнээс үзэхэд 10.000 хүн амд бэлгийн замын үрэвсэлт өвчин 527 ноогдож байсан бөгөөд тэдгээрийн 80 гаруй хувь нь үтрээний үрэвсэл, умайн хүзүүний шархлаа эзэлж байна гэснээс өөр тоо баримт одоогоор ховор байгаа билээ.

Эдийн засгийн бэрхшээл учирч буй зах зээлийн шилжилтийн үе болох өнөөгийн нөхцөлд гэр бүл, хувь хүний амьдралын түвшин доройтсонтой холбоотой бэлгийн замаар дамжин халдварладаг өвчин нэмэгдэх хандлагатай байна. Бэлгийн замаар дамжин халдварладаг өвчин ихсэхэд нөлөөлж буй хэд хэдэн эмзэг байдал бий боллоо. Үүнд:

1. Сүүлийн жилүүдэд хялбар аргаар мөнгө олох гэсэн хүсэлдээ хөтлөгдөн хот, суурин газруудад 800 гаруй охид, эмэгтэйчүүд биеэ үнэлж, улсын хэмжээнд нөхөргүй 20.000 гаруй эмэгтэйчүүд / ДОХ-ын Үндэсний Төвийн 1995 оны мэдээлэл/ байгаа нь бэлгийн замын халдвар хотод ч хөдөөд ч тархах нөхцлийг бүрдүүлж байна.

2. 24000 гаруй өсвөр насныхан болон залуучууд сургууль завсардсан, 70.000 гаруй хүмүүс ажилгүй хэмээн бүртгэгджээ. Тэрчлэн залуучуудын дотор архидах үзэгдэл ихээхэн дэлгэрч байгаа зэрэг нь бэлгийн замын халдварт өвчин тархахад нөлөөлж болохоор байна.

3. Сүүлийн жилүүдэд садар самууныг сурталчилсан олон тооны сонин сэтгүүл хэвлэгдэн тараагдаж байгаагаас гадна ийм төрлийн кино бусад

сурталчилгааны зүйл гадаадаас олноор оруулж ирэн олшруулан худалдаж байгаа нь ялангуяа өсвөр насныхны бэлгийн хүмүүжлийн төлөвшилтөнд муугаар нөлөөлсөөр байна. Иймээс бид эмэгтэйчүүдийн бэлэг эрхтний үрэвсэлт өвчний шалтгаан, тархалт бүтцийг судлан тогтоож, төгс эмчлэх, цаашид бууруулах арга зүйг боловсруулах зорилгоор энэхүү судалгааны ажлыг явуулахыг зорьсон юм.

Судалгааны ажлыг Монгол орны говь, тал хээр, хангайн бүсийн олон ястан үндэстний эмэгтэйчүүдийг хамруулж, бэдгийн замын үрэвсэлт өвчний шалтгаан, тархалт бүтцийг байгаль цаг уур, газарзүйн онцлог, ард иргэдийн ёс заншил, амьдралын байдалтай нь харьцуулан 4 аймгийн 12 сум, Улаанбаатар хотын 1 дүүргийг хамруулан тарах насны 2500 эмэгтэйчүүдэд судалгааны санамсаргүй сонголтын аргыг хэрэглэж түүвэрлэн авч асууж, эмэгтэйчүүдийн үзлэг, лабораторийн шинжилгээтэй бүрдмэл байдлаар 1995 оны 8-10 дугаар сард явуулж боловсруулалт, дүгнэлтийг гаргасан юм.

Судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийг насны байдлаар авч үзвэл 24-34 насны эмэгтэйчүүд 41.1 хувийг эзэлж байгаа бөгөөд энэ нь идэвхтэй төрөх насны эмэгтэйчүүд судалгаанд илүү хамрагдсаныг харуулж байна. Мөн 77.3 хувь нь дунд, тусгай дунд боловсролтой эмэгтэйчүүд байгаа нь Монголын хүн амын боловсролын түвшиний ерөнхий харьцаатай тохирч байна.

Судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн 65.2 хувь нь дунд зэрэг, 2.8 % нь ядуу, 2.0 % нь хангалуун амьдардаг хэмээн хариулжээ. Мөн олонхи нь 87.5% ажлын энгийн нөхцөлтэй тул эрүүл мэндэд ажлын нөхцөл хамаарах үндэслэл бага байна. 32.8 % нь өөрийгөө урьд нь эмэгтэйчүүдийн үрэвсэлт өвчнөөр өвдөж байсан, 28.1 % нь одоо ийм өвчтэй, 16.3 % нь өвчтэй эсэхээ мэдэхгүй гэж хариулжээ.

Судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн ихэнх нь 89.2 % анх удаа гэрлэсэн эмэгтэйчүүдийн эмэгтэйчүүд байв. Төрөх насны эмэгтэйчүүдийн нөхрүүд эмчид үзүүлж эрүүл мэндээ анхаарах нь бага байна. Нөхрүүдийн 90 % нь эмчид хааяа үзүүлдэг буюу огт үзүүлдэггүй ажээ.

Эмэгтэйчүүдийн үрэвсэлт өвчний шалтгаан, эмчилгээний үр дүн нь жирэмсэн ба түүний төгсгөл ямар байснаас ихээхэн шалтгаалдаг. Ялангуяа умай дайврын үрэвсэл нь үр хөндөлт, халдварлагдсан зулбааны дараа үүсэх, сэдрэх явдал их байдаг.

Бид судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдээс хэдэн удаа жирэмсэлж, тэр нь зулбалт, төрөлт, үр хөндөлт, умайн гаднах жирэмсний аль нэгээр нь хэрхэн төгссөн тухай асуусан юм. Жирэмсэлсэн 2212 эмэгтэй энэ асуултанд хариулсан нь нийт судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн 88.4 % байна. Тэдний 18.4 % нь 2 удаа, 17.7 % нь 1 удаа, 14.9 % нь 3 удаа 14.6 % нь 4 удаа тус тус тус жирэмсэлсэн нь олонхи 65.6 % байна.

сурталчилгааны зүйл гадаадаас олноор оруулж ирэн олшруулан худалдаж байгаа нь ялангуяа өсвөр насныхны бэлгийн хүмүүжлийн төлөвшилтөнд муугаар нөлөөлсөөр байна. Иймээс бид эмэгтэйчүүдийн бэлэг эрхтний үрэвсэлт өвчний шалтгаан, тархалт бүтцийг судлан тогтоож, төгс эмчлэх, цаашид бууруулах арга зүйг боловсруулах зорилгоор энэхүү судалгааны ажлыг явуулахыг зорьсон юм.

Судалгааны ажлыг Монгол орны говь, тал хээр, хангайн бүсийн олон ястан үндэстний эмэгтэйчүүдийг хамруулж, бэдгийн замын үрэвсэлт өвчний шалтгаан, тархалт бүтцийг байгаль цаг уур, газарзүйн онцлог, ард иргэдийн ёс заншил, амьдралын байдалтай нь харьцуулан 4 аймгийн 12 сум, Улаанбаатар хотын 1 дүүргийг хамруулан тарах насны 2500 эмэгтэйчүүдэд судалгааны санамсаргүй сонголтын аргыг хэрэглэж түүвэрлэн авч асууж, эмэгтэйчүүдийн үзлэг, лабораторийн шинжилгээтэй бүрдмэл байдлаар 1995 оны 8-10 дугаар сард явуулж боловсруулалт, дүгнэлтийг гаргасан юм.

Судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийг насны байдлаар авч үзвэл 24-34 насны эмэгтэйчүүд 41.1 хувийг эзэлж байгаа бөгөөд энэ нь идэвхтэй төрөх насны эмэгтэйчүүд судалгаанд илүү хамрагдсаныг харуулж байна. Мөн 77.3 хувь нь дунд, тусгай дунд боловсролтой эмэгтэйчүүд байгаа нь Монголын хүн амын боловсролын түвшиний ерөнхий харьцаатай тохирч байна.

Судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн 65.2 хувь нь дунд зэрэг, 2.8 % нь ядуу, 2.0 % нь хангалуун амьдардаг хэмээн хариулжээ. Мөн олонхи нь 87.5% ажлын энгийн нөхцөлтэй тул эрүүл мэндэд ажлын нөхцөл хамаарах үндэслэл бага байна. 32.8 % нь өөрийгөө урьд нь эмэгтэйчүүдийн үрэвсэлт өвчнөөр өвдөж байсан, 28.1 % нь одоо ийм өвчтэй, 16.3 % нь өвчтэй эсэхээ мэдэхгүй гэж хариулжээ.

Судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн ихэнх нь 89.2 % анх удаа гэрлэсэн эмэгтэйчүүдийн эмэгтэйчүүд байв. Төрөх насны эмэгтэйчүүдийн нөхрүүд эмчид үзүүлж эрүүл мэндээ анхаарах нь бага байна. Нөхрүүдийн 90 % нь эмчид хааяа үзүүлдэг буюу огт үзүүлдэггүй ажээ.

Эмэгтэйчүүдийн үрэвсэлт өвчний шалтгаан, эмчилгээний үр дүн нь жирэмсэн ба түүний төгсгөл ямар байснаас ихээхэн шалтгаалдаг. Ялангуяа умай дайврын үрэвсэл нь үр хөндөлт, халдварлагдсан зулбааны дараа үүсэх, сэдрэх явдал их байдаг.

Бид судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдээс хэдэн удаа жирэмсэлж, тэр нь зулбалт, төрөлт, үр хөндөлт, умайн гаднах жирэмсний аль нэгээр нь хэрхэн төгссөн тухай асуусан юм. Жирэмсэлсэн 2212 эмэгтэй энэ асуултанд хариулсан нь нийт судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн 88.4 % байна. Тэдний 18.4 % нь 2 удаа, 17.7 % нь 1 удаа, 14.9 % нь 3 удаа 14.6 % нь 4 удаа тус тус тус жирэмсэлсэн нь олонхи 65.6 % байна.

Төрөлт, зулбаа, умайн гаднах жирэмслэлт,
тэдгээрийн хүдрэлийг өвчлөлтэй харьцуулсан байдал

Хүснэгт 1.

| | Төрөхийн хүндрэл | | | | | | Зулбаа | | Үр хөндөлт | | Умайн гаднах | |
|---|------------------------------|-------------|-------------|----------------|-------------|-------------|------------|-------------|------------|-------------|--------------|--------------|
| | Цус алдсан | Хал двар | Ихэс гардах | Кес. хага лгаа | Ус эрт гарс | Умайг гар-р | Хэв-ийн | Халд вар | Хэв-ийн | Халд вар | Хүн дрэл гүй | Хүн дрэл тэй |
| 1 | Энгийн кольпит /940/ | 117 12.4 | 14 1.5 | 86 9.1 | 22 2.3 | 53 5.6 | 24 2.6 | 166 17.7 | 6 0.6 | 279 29.7 | 8 0.9 | 3 0.3 |
| | Заг гаралтай кольпит /33/ | 3 9.1 | | 2 6.1 | 1 3.0 | 3 9.1 | 2 6.1 | 4 12.1 | | 9 27.3 | 1 3.0 | 1 3.0 |
| | Трихомонадын кольпит /212/ | 17 8.0 | 1 0.5 | 14 6.6 | 9 4.2 | 4 1.9 | 3 1.4 | 37 17.5 | 2 0.9 | 62 29.2 | | 3 1.4 |
| | Бусад кольпит /14/ | 1 7.1 | | | 1 7.1 | 2 14.3 | | 4 28.6 | | 8 57.1 | 1 7.1 | |
| | Умайн хүзүүний шархлаа /452/ | 60 35.7 | 3 18.8 | 46 39.7 | 7 20.0 | 17 21.3 | 11 29.7 | 72 30.4 | 5 41.7 | 141 32.9 | 3 27.3 | 4 30.8 |
| 2 | Эндометрит /77/ | 9 11.7 | 3 3.9 | 12 15.6 | 2 2.6 | 5 6.5 | 2 2.6 | 19 24.7 | 2 2.6 | 35 45.5 | 1 1.3 | 1 100.0 |
| | Метроэндометрит /9/ | 1 11.1 | | | 1 11.1 | | 2 22.2 | 6 66.7 | 2 22.2 | 4 44.4 | | |
| 3 | Сальпингит /68/ | 12 17.6 | | 7 10.3 | 2.2 | 7 10.3 | 1 1.5 | 19 27.9 | 2 2.9 | 29 42.6 | 1 1.5 | 1 1.5 |
| | Өндгөвчний үрэвсэл /229/ | 35 15.3 | 2 0.9 | 26 11.4 | 5 2.2 | 23 10.0 | 11 4.8 | 55 24.0 | 4 1.7 | 97 42.4 | 6 2.6 | 2 0.9 |
| 4 | Пиелонефрит /132/ | 17 12.8 | | 12 9.1 | 8 6.0 | 10 7.6 | 6 5.5 | 22 16.7 | 1 0.7 | 43 32.6 | 3 2.3 | 1 0.7 |
| | Цистит /107/ | 13 12.1 | | 11 10.3 | 2 1.9 | 4 3.7 | 4 3.7 | 20 18.7 | 1 0.9 | 34 31.8 | 2 1.9 | 1 0.9 |
| | Пиелоцистит /20/ | 4 20.0 | 1 5.0 | 4 20.0 | | 2 10.0 | 1 5.0 | 6 30.0 | 2 10.0 | 9 45.0 | | 1 5.0 |

Төрөхийн хүндрэл ялангуяа эхэс гардалт, ус эрт гарах, зулбаа, үр хөндөлт, зэрэг нь ЭҮӨ-тэй шууд хамааралтай нь харагдаж байна. Жирэмсний төгсгөлийн хүндрэлийн тохиолдлыг тухайн өвчтэй эмэгтэйчүүдийн дотор эзлэх хувиар авлаа. Жишээ нь: Судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдээс төрөхдөө цус алдсан, энгийн кольпиттой 117 тохиолдол бүртгэгдсэн нь судалгааны явцад илэрсэн энгийн кольпиттой 940 эмэгтэйн 12.4 % гэж ойлгоно.

Урьд эмэгтэйчүүдийн үрэвсэлт өвчнөөр өвчилж байсан эмэгтэйчүүд дахин өвчлөх магадлал өндөр байна. Үүний шалтгааныг гэр бүл, эрүүл ахуйн хэвшсэн заншлаас гадна ЭҮӨ-ийг дутуу эмчлэх, огт эмчлүүлээгүй байх түүнчлэн нөхөр нь хамт эмчлэгдээгүй зэрэг олон шалтгаантай холбон тайлбарлах үндэслэлтэй.

Урьд нь ЭҮӨ-өөр өвчилж байсныг одоогийн
өвчлөлтэй харьцуулсан нь:


Хүснэгт 2.

| Одоо байгаа ЭҮӨ | | ГБЭ-ний өвчин | | | Үтрээ, умайн хүзүүний үрэвсэл | | | | |
|---------------------------|------|------------------|--------------------|--------------------|-------------------------------|--------------------|----------------------------------|-------------------|-----------------------------|
| Урьд нь өвчилж байсан ЭҮӨ | Бүгд | Буль- вит | Барт олан ит | Кон- деле ма | Энг- ийн коль пит | Заг коль пит | Трихо- мона- дын колпит | Бусад колпит | Умайн хүзүүний улайлт |
| ГБЭ, үтрээний үрэвсэл | 547 | 8 1.4 16.0 | 1 0.2 9.0 | 2 0.36 66.6 | 175 31.9 18.6 | 7 1.3 21.2 | 51 9.3 24.0 | 2 0.36 14.3 | 101 18.5 22.3 |
| Умайн хүзүүний улайлт | 562 | 8 1.4 16.0 | | | 195 34.7 20.7 | 8 1.4 24.2 | 51 9.0 24.0 | 4 0.7 28.5 | 143 25.4 31.6 |
| Умайн үрэвсэл | 62 | 1 1.6 2.0 | 1 1.6 9.0 | | 26 41.9 2.7 | 1 1.6 3.0 | 2 3.2 0.9 | | 13 20.9 2.8 |
| Өндгөвчний үрэвсэл | 189 | 1 0.5 2.0 | 1 0.5 9.0 | 1 0.5 33.3 | 67 35.9 7.1 | 3 1.6 9.0 | 9 4.8 4.2 | 2 1.0 14.3 | 36 19.0 7.9 |
| Заг хүйтэн | 18 | 3 16.7 6.0 | | | 3 16.7 0.3 | 4 22.2 12.1 | 5 27.7 2.3 | 1 5.5 7.1 | 2 11.1 0.4 |
| Тирхомонад | 21 | 4 19.0 | | | 3 14.2 0.3 | 3 14.2 9.0 | 10 47.6 4.7 | 1 4.7 7.1 | 7 33.3 1.5 |
| тэмбүү | 3 | | | | 2 66.6 0.2 | | | | |
| Бүгд | | 50 | 11 | 3 | 940 | 33 | 212 | 14 | 452 |

Тайлбар: Босоо баганын 1-рт тохиолдлын тоо, 2-рт хэвтээ баганд эзлэх хувь, 3-рт босоо багананд эзлэх хувь тус тус байна. Жишээ нь: Одоо гадна бэлэг эрхтний вульвит өвчтэй урьд нь үтрээний үрэвслээр өвчилж байсан 8 хүн байгаа нь урьд үтрээний үрэвслээр өвчилсөн 547 эмэгтэйн 1.4% бөгөөд одоо вульвит өвчтэй 50 эмэгтэйн 16.0 хувь гэж ойлговол зохино.

Бид судалгаанд эмэгтэйчүүдээс асуумж авч, үзлэг, шинжилгээ хийсний үр дүнд бэлгийн замын үрэвсэлт өвчний тархалт, бүтцийг тогтоосон юм. Судалгаанд хамрагдсан 2500 эмэгтэйчүүдийн дотор гадна бэлэг эрхтний үйл үрэвсэл 2.96% эзэлж, ихэвчлэн залуу, төрөөгүй эмэгтэйчүүдэд тохиолдож

байна. Мөн 37.6 % нь энгийн кольпит, 18.1 % нь умайн хүзүүний шархлаа, 11.1 % нь умайн хүзүүний сувгийн үрэвсэлтэй, 8.5 % нь трихомонадын кольпиттой байна. Үтрээний үрэвсэл 20–35 насанд, умайн үрэвсэл 3.5 % тохиолдож, умайн хүзүүний шархлаа, умай ба түүний дайврын үрэвслээр гэрлэсэн, олон жирэмсэлсэн, үр хөндүүлж, зулбасан эмэгтэйчүүд илүү өвчилж байна.



Судалгааны үр дүнд бид дараахи дүгнэлтийг хийв.

1. Бэлгийн замын үрэвсэлт өвчин Монгол эмэгтэйчүүдэд элбэг тохиолдож ихэвчлэн хавсарсан хэлбэртэй байна.

2. Үрэвсэлт өвчний эмчилгээг үүсгэгчийн эсрэг, нөхөртэй нь хамт төгс хийдэггүйгээс дахих, архагших хандлага элбэг байна.

3. Бэлгийн замын үрэвсэлт өвчний шалтгаан нь ариун цэврийн дадал, амьдралын орчин нөхцөл, бэлгийн хүмүүжил, соёл/ ялангуяа эмэгтэйчүүдийн/ түүнчлэн өвчний хурц үеийн эмчилгээ дутмагаас ихэвчлэн болж байна.

4. Олон удаа үр хөндүүлэх, зулбах, түүнчлэн хүндрэлтэй төрөх нь үрэвсэлт өвчнийг ихэсгэхэд нөлөөлж байна.

Ашигласан материал:

1. "Нөхөн үржихүний насны эмэгтэйчүүдийн шээс, бэлгийн замын үрэвсэлт өвчний судлагаа" 1995 он

2. "Эсэн мэнд амаржихуй" сэтгүүл. 1996 он

3. "Хүүхэд, эх барих эмэгтэйчүүдийн тулгамдсан асуудал" илтгэлийн хураангуй. 1997 он

4. Эрүүл Мэндийн Яам /1992/ "Гэр бүл төлөвлөлтийн анхдугаар хуралдаан" Улаанбаатар

5. "Монголын хүн ам зүйн сэтгүүл" 1997 он